СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

СБА-2022/03/НА-СТА-ТШЗ


Тэргүүлэх аудитор: М.Нарантуяа
Утас: 70518369 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Даваа
Утас: 70512123 Цахим хаяг: davaag@audit.gov.mn
Аудитор: А.Мөнхцэцэг
Утас: 70512127 Цахим хаяг: Munkhtsetsega@audit.gov.mn



Цахим хуудас: www.audit.mn

Баруун-Урт сум

2022 он


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....... 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....... 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....... 4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....... 6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....... 6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....... 8
3. Аудитын тайлан....... 9
3.1 Ерөнхий зүйл....... 9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ....... 9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....... 9
3.4 Материаллаг байдал ....... 9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга....... 10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....... 11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг....... 11
3.8 Аудитын гол асуудал ....... 11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....... 11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт....... 12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....... 12
4.1 Зөвлөмж....... 12

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2022.02.25 № 28

танай ______________-ны №______________-т

СҮХБААТАР АЙМГИЙН ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Ц.ГАНХУЯГ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шүүхийн тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.НАРАНТУЯА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **26,661,113.73** | **19,235,481.20** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 26,661,113.73 | 19,235,481.20 |
| **354** | **Хангамжийн материал** | 24,934,138.00 | 17,717,479.50 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,574,480.00 | 1,428,450.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 19,836,458.00 | 15,799,029.50 |
| 35450 | Барилгын засварын материал | 2,523,200.00 | 490,000.00 |
| 35600 | Мал амьтад | 1,726,975.73 | 1,518,001.70 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **625,048,889.00** | **721,293,510.32** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 625,048,889.00 | 721,293,510.32 |
| **392** | **Биет хөрөнгө** | 565,428,889.00 | 661,673,510.32 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 480,665,000.00 | 480,665,000.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -17,501,628.24 | -26,252,442.36 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 33,692,900.00 | 127,790,400.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -4,854,285.42 | -12,365,597.94 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 89,333,454.50 | 111,496,401.50 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -44,892,288.63 | -42,321,449.83 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 81,001,905.10 | 79,172,124.37 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -56,995,967.79 | -61,200,156.54 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 6,138,868.20 | 6,138,868.20 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -1,252,068.72 | -1,825,669.08 |
| 39217 | Ном | 93,000.00 | 376,032.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 59,620,000.00 | 59,620,000.00 |
| 39301 | Програм хангамж | 1,550,000.00 | 1,550,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -550,000.00 | -550,000.00 |
| 39305 | Газар | 58,620,000.00 | 58,620,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **651,710,002.73** | **740,528,991.52** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **651,710,002.73** | **740,528,991.52** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 651,710,002.73 | 740,528,991.52 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 517,169,325.00 | 517,169,325.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 517,169,325.00 | 517,169,325.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -500,140,539.65 | -411,321,550.86 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -545,516,836.08 | -500,140,539.65 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 45,376,296.43 | 88,818,988.79 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 634,681,217.38 | 634,681,217.38 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **651,710,002.73** | **740,528,991.52** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,154,624,633.01** | **1,234,095,620.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **71,834,333.01** | **126,398,220.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 71,834,333.01 | 126,398,220.00 |
| 120009 | Бусад орлого | 48,984,653.01 | 726,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй орлого Үндсэн хөрөнгө | 21,951,340.00 | 125,306,764.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй орлого Бараа материал | 898,340.00 | 365,456.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,082,790,300.00** | **1,107,697,400.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,082,090,300.00 | 1,107,697,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,082,090,300.00 | 1,107,697,400.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 700,000.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 700,000.00 | 00.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,109,248,336.58** | **1,145,276,631.21** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,109,248,336.58** | **1,145,276,631.21** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,092,579,326.58 | 1,140,327,032.10 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 831,859,300.00 | 851,493,476.89 |
| 210101 | Үндсэн цалин | 655,415,400.00 | 657,133,804.23 |
| 210102 | Нэмэгдэл | 136,503,200.00 | 141,380,405.51 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 25,032,500.00 | 24,153,048.15 |
| 210104 | Урамшуулал | 14,908,200.00 | 28,826,219.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 112,492,200.00 | 107,492,200.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 80,044,300.00 | 76,644,300.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,112,000.00 | 7,712,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,489,600.00 | 6,409,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,622,400.00 | 2,567,959.86 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,223,900.00 | 14,158,340.14 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 35,747,170.00 | 45,337,384.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,818,900.00 | 4,766,734.00 |
| 210302 | Түлш, халаалт | 28,103,400.00 | 37,095,050.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,824,870.00 | 3,475,600.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 52,549,593.92 | 66,576,845.53 |
| 210401 | Бичиг хэрэг | 11,166,424.00 | 14,515,856.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 19,401,400.00 | 17,651,997.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 8,757,900.00 | 8,439,787.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 600,000.00 | 590,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 11,420,809.00 | 24,444,231.50 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 1,203,060.92 | 934,974.03 |
| **2105** | **Нормативт зардал** | 800,000.00 | 00.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 800,000.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 17,569,350.00 | 16,721,133.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 20,000.00 | 947,919.00 |
| 210604 | Урсгал засвар | 17,549,350.00 | 15,773,214.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 7,968,300.00 | 8,609,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,968,300.00 | 8,609,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,413,040.00 | 6,622,450.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,911,440.00 | 4,842,750.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 720,000.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 615,000.00 | 615,200.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 109,400.00 | 57,300.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 1,050,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 35,200.00 | 35,200.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 28,180,372.66 | 37,474,142.68 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 28,180,372.66 | 37,474,142.68 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 16,669,010.00 | 4,949,599.11 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 13,693,000.00 | 3,000,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 13,693,000.00 | 3,000,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,976,010.00 | 1,949,599.11 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,976,010.00 | 1,949,599.11 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **45,376,296.43** | **88,818,988.79** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **45,376,296.43** | **88,818,988.79** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 517,169,325.00 | 634,681,217.38 | -545,516,836.08 | 00.00 | 606,333,706.30 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **517,169,325.00** | **634,681,217.38** | **-545,516,836.08** | **00.00** | 606,333,706.30 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 45,376,296.43 | 00.00 | 45,376,296.43 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **517,169,325.00** | **634,681,217.38** | **-500,140,539.65** | **00.00** | 651,710,002.73 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 88,818,988.79 | 00.00 | 88,818,988.79 |
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **517,169,325.00** | **634,681,217.38** | **-411,321,550.86** | **00.00** | 740,528,991.52 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,082,790,300.00** | **1,107,697,400.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,082,790,300.00** | **1,107,697,400.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,082,090,300.00 | 1,107,697,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,082,090,300.00 | 1,107,697,400.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 700,000.00 | 00.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 700,000.00 | 00.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,081,090,300.00** | **1,099,285,400.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,081,090,300.00** | **1,099,285,400.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,064,421,290.00** | **1,094,335,800.89** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 831,859,300.00 | 851,493,476.89 |
| 210101 | Үндсэн цалин | 655,415,400.00 | 657,133,804.23 |
| 210102 | Нэмэгдэл | 136,503,200.00 | 141,380,405.51 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 25,032,500.00 | 24,153,048.15 |
| 210104 | Урамшуулал | 14,908,200.00 | 28,826,219.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 112,492,200.00 | 107,492,200.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 80,044,300.00 | 76,644,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,112,000.00 | 7,712,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,489,600.00 | 6,409,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,622,400.00 | 2,567,959.86 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,223,900.00 | 14,158,340.14 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 35,747,900.00 | 45,337,384.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,818,900.00 | 4,766,734.00 |
| 210302 | Түлш, халаалт | 28,103,400.00 | 37,095,050.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,825,600.00 | 3,475,600.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 47,757,650.00 | 50,779,639.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 12,024,050.00 | 12,982,372.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 19,397,100.00 | 17,651,997.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 8,757,900.00 | 8,439,787.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 600,000.00 | 590,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,978,600.00 | 11,115,483.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 800,000.00 | 800,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 800,000.00 | 800,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 22,382,900.00 | 23,201,251.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,382,900.00 | 9,082,237.00 |
| 210604 | Урсгал засвар | 20,000,000.00 | 14,119,014.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 7,968,300.00 | 8,609,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,968,300.00 | 8,609,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,413,040.00 | 6,622,450.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,911,440.00 | 4,842,750.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 720,000.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 615,000.00 | 615,200.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 109,400.00 | 57,300.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 1,050,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 35,200.00 | 35,200.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **16,669,010.00** | **4,949,599.11** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 13,693,000.00 | 3,000,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 9,693,000.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,000,000.00 | 3,000,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,976,010.00 | 1,949,599.11 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,976,010.00 | 1,949,599.11 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **1,700,000.00** | **8,412,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **1,700,000.00** | **8,412,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **1,700,000.00** | **8,412,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 1,700,000.00 | 8,412,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 1,700,000.00 | 8,412,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-1,700,000.00** | **-8,412,000.00** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,107,697,400.00 | 1,105,747,800.89 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,107,697,400.00 | 1,105,747,800.89 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,104,697,400.00 | 1,102,747,800.89 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 853,274,300.00 | 851,493,476.89 |
| 210101 | Үндсэн цалин | 676,830,400.00 | 657,133,804.23 |
| 210102 | Нэмэгдэл | 136,503,200.00 | 141,380,405.51 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 25,032,500.00 | 24,153,048.15 |
| 210104 | Урамшуулал | 14,908,200.00 | 28,826,219.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 107,492,200.00 | 107,492,200.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 76,644,300.00 | 76,644,300.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,712,000.00 | 7,712,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,409,600.00 | 6,409,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,302,400.00 | 2,567,959.86 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,423,900.00 | 14,158,340.14 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 45,389,900.00 | 45,337,384.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,818,900.00 | 4,766,734.00 |
| 210302 | Түлш, халаалт | 37,095,400.00 | 37,095,050.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,475,600.00 | 3,475,600.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 50,780,900.00 | 50,779,639.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 13,013,000.00 | 12,982,372.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 17,660,000.00 | 17,651,997.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 8,957,900.00 | 8,439,787.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 600,000.00 | 590,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 10,550,000.00 | 11,115,483.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 800,000.00 | 800,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 800,000.00 | 800,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 31,620,000.00 | 31,613,251.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 17,500,000.00 | 17,494,237.00 |
| 210604 | Урсгал засвар | 14,120,000.00 | 14,119,014.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 8,609,400.00 | 8,609,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 8,609,400.00 | 8,609,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 6,730,700.00 | 6,622,450.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,898,900.00 | 4,842,750.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 615,200.00 | 615,200.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 109,400.00 | 57,300.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,050,000.00 | 1,050,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 35,200.00 | 35,200.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 3,000,000.00 | 3,000,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 3,000,000.00 | 3,000,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,000,000.00 | 3,000,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,107,697,400.00 | 1,105,747,800.89 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,107,697,400.00 | 1,105,747,800.89 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,107,697,400.00 | 1,105,747,800.89 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 38 | 38 |
| 620001 | Удирдах ажилтан | 5 | 5 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 28 | 28 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 5 | 5 |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 38 | 38 |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 15 | 15 |
| 650002 | Төрийн тусгай албан хаагч (ТТ) | 12 | 12 |
| 650003 | Ажлын албаны албан хаагч (АА) | 11 | 11 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Шүүхийн тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-наас 2022 оны 2 дугаар сарын 25-ны хооронд Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Мөнхцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05/24 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сүхбаатар аймгийн Шүүхийн Тамгын газар нь шүүн таслах ажиллагааг хэвийн тасралтгүй явуулах нөхцөл боломжоор хангаж, шүүх шүүгчийн аюулгүй байдлыг хангаж хамгаалах үндсэн зорилт чиг үүрэгтэй үйл ажиллагаа явуулдаг ШЕЗ-ийн харьяа байгууллага юм.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн нь хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд нийт ажил гүйлгээний ихэнх хувийг зардлын гүйлгээ эзэлдэг бөгөөд

төсвийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байдлыг татвар төлөгч, иргэд илүү анхаардаг учир материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 1,109.2 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 22.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 18.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сүхбаатар аймгийн Шүүхийн тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 88.8 сая төгрөг буюу 13.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая.төг/

| **Үзүүлэлт** | **Эхний үлдэгдэл** | **Эцсийн үлдэгдэл** | **Өөрчлөлт** |
|---|---|---|---|
| **Б** | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0 | 0 | 0 |
| Авлага | 0 | 0 | 0 |
| Бараа материал | 26.6 | 19.2 | -7.4 |
| Үндсэн хөрөнгө | 625.0 | 721.3 | 96.2 |
| **Нийт хөрөнгө** | **651.7** | **740.5** | **88.8** |
| Өр төлбөр | | | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | **651.7** | **740.5** | **88.8** |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **651.7** | **740.5** | **88.8** |

- Бараа материалын дансны үлдэгдэл 19.2 сая төгрөг болж 7.4 сая төгрөгөөр буурсан байна. Бараа материал данс буурсан нь эхний үлдэгдлээс зарцуулсан байна.

- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 721.3 сая төгрөг болж 96.2 сая нэмэгдсэн байна. ШЕЗ-д тендер зарлагдан үнэ төлбөргүй 94.1 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж 30.9 сая, бусад 0.3 сая төгрөгийн нийт 125.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Сүхбаатар аймгийн Шүүхийн тамгын газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1.234.0 сая төгрөг буюу 6.9 хувиар нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлогын данс байна. Тодруулбал тайланд 125.3 сая төгрөг үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсан нь нөлөөлжээ.

Нийт зардал өмнөх оноос 36.1 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гараагүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 193.7 сая төгрөгөөр бууруулж 1.054.2 сая төгрөгөөр баталсан байна. Харин төсвийн тодотголоор тус байгууллагын төсөв 53.5 сая төгрөгөөр нэмэгджээ.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,107.7 сая төгрөгийн төсөв баталснаас 1,107.7 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,107.6 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,105.7 сая төгрөг зарцуулж 1.9 сая төгрөгийн төсвийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Монгол Улсын Шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 85 дугаар зүйлийн 85.2-д “Улсын дээд шүүхээс бусад шүүхийн Тамгын газар үйл ажиллагаагаа Ерөнхий зөвлөлд тайлагнана.”, Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоол “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох тайлан гаргах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.5.2-т “Төсвийн шууд захирагч 12 дугаар сарын 15-ны өдрийн тодор харьяалах төрийн захиргааны төв байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ” гэж тус тус заасны дагуу Сүхбаатар аймаг дахь шүүхийн Тамгын газар 2021 онд хийж гүйцэтгэсэн ажлаа тайлагнан ажиллажээ.

Шүүхийн тамгын газар гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 45 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжүүлжээ. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс жил бүр үзүүлэлт бүрээр үйл ажиллагааг нь тусгайлсан журмаар үнэлдэг бөгөөд тамгын газар нь 86.88%-иар үнэлэгдсэн байна.

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Сүхбаатар аймгийн Шүүхийн Тамгын газрын үйл ажиллагаа, тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээ, үйл явдал болон засаглах эрх бүхий этгээдүүдийн түвшин дэх харилцаатай холбоотой санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын

талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах асуудал гараагүй.

**3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллийг хуулийн хугацаанд шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн байна.

**3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн,бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг илүү бодож олгосон 949.0 мянган төгрөгийн зөрчил дутагдал төлбөрийн акт тогтоогдсон. Төлбөрийн актыг барагдуулж бүрэн хэрэгжсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сүхбаатар аймгийн Шүүхийн тамгын газрын тайлант оны үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл, ажил гүйлгээ болон санхүүгийн тайланг тасалбар болгож гаргасан өдрөөс хойших үйл явдлыг шинжилж үзэхэд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

**4.1 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал***

*<u>1.1. Илрүүлэлт:</u>*

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 37 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан "Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана" заалттай нийцэхгүй байна.

*<u>1.2. Өгсөн зөвлөмж:</u>*

Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.